

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн  
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/065/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас:88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: [munkhtuya2220@gmail.com](mailto:munkhtuya2220@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/173  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаан-Уул сумын эрүүл мэндийн төв нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,335,680.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 1,211,708.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 123,972.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 18,853.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Улаан-Уул сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2024 оны гэрээний биелэлтийг 73.4 хувьтай дүгнэсэн байна.

2025.02.25

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>167,802,265.72</u></b>	<b><u>256,383,169.44</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	731,371.12	4,746,665.22
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	731,371.12	4,746,665.22
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	731,371.12	4,746,665.22
31211	Төрийн сангийн харилцах	731,371.12	4,746,665.22
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	42,767,023.00	123,972,848.21
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	42,767,023.00	123,972,848.21
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	0.00	2,312,026.00
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	2,312,026.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	124,303,871.60	125,351,630.01
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	41,673,630.88	44,750,653.76
35130	Эм боох материал	41,673,630.88	44,750,653.76
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	82,630,240.72	80,600,976.25
35410	Бичиг хэргийн материал	258,850.00	238,100.00
35420	Аж ахуйн материал	58,406,701.70	63,228,006.17
35440	Түлш, шатах тослох материал	9,542,150.02	2,333,880.08
35460	Хүнсний материал	1,687,939.00	2,066,390.00
35470	Бусад хангамжийн материал	12,734,600.00	12,734,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>700,166,247.80</u></b>	<b><u>847,399,049.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	700,166,247.80	847,399,049.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	659,968,247.80	807,201,049.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	373,606,381.42	373,606,381.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	(57,690,187.71)	(68,163,673.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	152,029,449.75	282,452,681.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(94,663,760.38)	(124,434,171.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	452,355,934.75	573,225,280.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,282,178.43)	(254,162,663.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,364,733.53	40,784,733.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,478,141.96)	(26,687,936.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,070,540.00	17,070,540.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,589,523.17)	(6,735,121.29)
39217	Ном	245,000.00	245,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	40,198,000.00	40,198,000.00
39301	Программ хангамж	15,400,000.00	15,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,198,000.00	25,198,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>867,968,513.52</u></b>	<b><u>1,103,782,218.87</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>5,218,965.00</u></b>	<b><u>9,408,160.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,218,965.00	9,408,160.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,218,965.00	9,408,160.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,218,965.00	4,934,460.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	4,473,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	4,473,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>862,749,548.52</u></b>	<b><u>1,094,374,058.87</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	862,749,548.52	1,094,374,058.87
511	Засгийн газрын сан	366,022,288.00	366,022,288.00
51101	Өмч: - төрийн	366,022,288.00	366,022,288.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	380,997,944.65	612,763,014.00
51210	Өмнөх үеийн үр дүн	380,997,944.65	381,138,503.65
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	231,624,510.35

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115,729,315.87	115,588,756.87
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>867,968,513.52</b>	<b>1,103,782,218.87</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,006,120,872.83</b>	<b>1,665,627,425.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>69,846,597.65</b>	<b>334,118,766.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	69,846,597.65	334,118,766.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	31,112,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	31,112,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	303,006,766.09
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>936,274,275.18</b>	<b>1,331,508,659.46</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35,199,200.00	38,594,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,199,200.00	38,594,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	901,025,075.18	1,292,913,859.46
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	901,025,075.18	1,292,913,859.46
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,033,698,716.97</b>	<b>1,434,002,915.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,033,698,716.97</b>	<b>1,434,002,915.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,033,659,616.97	1,404,351,536.46
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	612,111,989.40	889,696,766.15
210101	Үндсэн цалин	366,444,555.42	470,710,935.88
210102	Нэмэгдэл	151,798,790.38	295,413,963.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,455,000.00	20,052,000.00
210104	Урамшуулал	77,191,262.60	103,519,866.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80,229,700.00	101,331,600.00
210201	Тэтгэврийн даатгал	56,157,000.00	73,239,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,700.00	7,908,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,256,500.00	3,600,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,045,400.00	3,600,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,641,100.00	12,983,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,865,091.40	37,021,541.23
210301	Гэрэл, цахилгаан	10,240,100.00	11,055,421.26
210302	Түлш, халаалт	23,599,991.40	25,966,119.97
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	67,374,269.49	85,559,411.07
210401	Бичиг хэрэг	4,559,520.00	3,478,170.00
210402	Тээвэр, шатахуун	41,259,555.49	49,575,715.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,338,500.00	3,015,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,647,310.00	11,064,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,417,844.00	5,114,680.00
210408	Бараа материал акталсны зардал	3,151,540.00	13,310,645.10
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	134,221,937.55	133,703,830.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,811,342.54	107,437,829.24
210502	Хоол, хүнс	23,827,095.01	26,266,001.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,307,923.00	6,500,800.00
210604	Урсгал засвар	13,307,923.00	6,500,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,004,000.00	4,831,600.00
210702	Дотоод албан томилолт	1,004,000.00	4,831,600.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,167,726.27	3,413,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,207,462.27	1,487,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,180.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,084.00	249,716.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	75,594.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	88,376,979.86	142,292,677.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,348,100.00	17,698,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,028,879.86	124,594,077.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	39,100.00	29,651,378.74
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	29,112,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	29,112,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	39,100.00	539,378.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,100.00	539,378.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-27,577,844.14</b>	<b>231,624,510.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-27,577,844.14</b>	<b>231,624,510.35</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>893,507,252.18</b>	<b>1,281,414,834.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>31,112,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	31,112,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	31,112,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	31,112,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>893,507,252.18</b>	<b>1,250,302,834.25</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	35,199,200.00	38,594,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,199,200.00	38,594,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	858,258,052.18	1,211,708,034.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	858,258,052.18	1,211,708,034.25
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>893,655,231.07</b>	<b>1,275,249,540.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>893,655,231.07</b>	<b>1,275,249,540.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>893,616,131.07</b>	<b>1,245,598,161.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	612,111,989.40	889,696,766.15
210101	Үндсэн цалин	346,010,575.42	470,710,935.88
210102	Нэмэгдэл	151,798,790.38	295,413,963.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,455,000.00	20,052,000.00
210104	Урамшуулал	97,625,242.60	103,519,866.48
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80,229,700.00	101,331,600.00
210201	Тэтгэврийн даатгал	55,670,100.00	73,239,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,700.00	7,908,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,743,400.00	3,600,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,266,200.00	3,600,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,420,300.00	12,983,600.00

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	33,665,100.00	35,055,421.26
210301	Гэрэл, цахилгаан	10,240,100.00	11,055,421.26
210302	Түлш, халаалт	23,400,000.00	24,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,853,990.00	64,524,112.00
210401	Бичиг хэрэг	2,945,270.00	3,299,320.00
210402	Тээвэр, шатахуун	43,131,720.00	46,645,592.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,228,500.00	3,015,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,160,000.00	2,925,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,388,500.00	8,638,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	74,966,025.40	125,763,552.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,821,025.40	96,319,100.00
210502	Хоол, хүнс	17,145,000.00	26,644,452.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,800,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,054,000.00	7,561,300.00
210604	Урсгал засвар	10,054,000.00	7,561,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,004,000.00	4,831,600.00
210702	Дотоод албан томилолт	1,004,000.00	4,831,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,374,226.27	3,413,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,207,462.27	1,487,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152,000.00	1,152,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	210,180.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	249,084.00	249,716.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	250,000.00	75,594.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,357,100.00	13,420,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,357,100.00	13,420,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,100.00</b>	<b>29,651,378.74</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	29,112,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	29,112,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	39,100.00	539,378.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,100.00	539,378.74
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-147,978.89</b>	<b>6,165,294.10</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>2,150,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>2,150,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	2,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,150,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-2,150,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(147,978.89)	4,015,294.10
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	879,350.01	731,371.12
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	731,371.12	4,746,665.22

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	340,824,288.00	93,308,650.08	54,817,792.09	488,950,730.17
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>340,824,288.00</b>	<b>93,308,650.08</b>	<b>54,817,792.09</b>	488,950,730.17
Тайлант үеийн үр дүн	25,198,000.00	0.00	(56,890,161.93)	(31,692,161.93)
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,022,288.00	115,729,315.87	380,997,944.65	862,749,548.52
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,022,288.00	115,729,315.87	380,997,944.65	862,749,548.52
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	140,559.00	140,559.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>366,022,288.00</b>	<b>115,729,315.87</b>	<b>381,138,503.65</b>	862,890,107.52
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	(140,559.00)	0.00	(140,559.00)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	231,624,510.35	231,624,510.35
<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>366,022,288.00</b>	<b>115,588,756.87</b>	<b>612,763,014.00</b>	1,094,374,058.87

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,354,939,700.00	1,238,804,740.15	91.43	116,134,959.85
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,354,939,700.00	1,238,804,740.15	91.43	116,134,959.85
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,274,939,700.00	1,209,692,740.15	94.88	65,246,959.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	936,188,800.00	889,696,766.15	95.03	46,492,033.85
210101	Үндсэн цалин	528,574,400.00	470,710,935.88	89.05	57,863,464.12
210102	Нэмэгдэл	301,257,300.00	295,413,963.79	98.06	5,843,336.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,600,000.00	20,052,000.00	159.14	(7,452,000.00)
210104	Урамшуулал	93,757,100.00	103,519,866.48	110.41	(9,762,766.48)
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	107,705,100.00	101,331,600.00	94.08	6,373,500.00
210201	Тэтгэврийн даатгал	73,239,500.00	73,239,500.00	100.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,616,400.00	7,908,500.00	91.78	707,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,308,200.00	3,600,000.00	83.56	708,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,308,200.00	3,600,000.00	83.56	708,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,232,800.00	12,983,600.00	75.34	4,249,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	70,342,300.00	66,674,112.00	94.79	3,668,188.00
210401	Бичиг хэрэг	3,416,900.00	3,299,320.00	96.56	117,580.00
210402	Тээвэр, шатахуун	49,555,100.00	46,645,592.00	94.13	2,909,508.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,015,700.00	3,015,700.00	100.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,925,000.00	2,925,000.00	100.00	0.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,429,600.00	10,788,500.00	94.39	641,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>127,746,000.00</b>	<b>125,763,552.00</b>	<b>98.45</b>	<b>1,982,448.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	105,636,300.00	96,319,100.00	91.18	9,317,200.00
210502	Хоол, хүнс	19,309,700.00	26,644,452.00	137.98	(7,334,752.00)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,800,000.00	100.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,581,000.00</b>	<b>4,561,300.00</b>	<b>60.17</b>	<b>3,019,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,285,700.00	0.00	0.00	2,285,700.00
210602	Тавилга	238,100.00	0.00	0.00	238,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	57,200.00	0.00	0.00	57,200.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,561,300.00	91.23	438,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,800,000.00</b>	<b>4,831,600.00</b>	<b>83.30</b>	<b>968,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,800,000.00	4,831,600.00	83.30	968,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,156,000.00</b>	<b>3,413,310.00</b>	<b>55.45</b>	<b>2,742,690.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	1,487,000.00	42.49	2,013,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,152,000.00	76.80	348,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	350,000.00	350,000.00	100.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	249,716.00	99.89	284.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	99,000.00	100.00	0.00
210807	Газрын төлбөр	250,000.00	75,594.00	30.24	174,406.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	207,000.00	0.00		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,420,500.00</b>	<b>13,420,500.00</b>	<b>100.00</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,420,500.00	13,420,500.00	100.00	0.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,000,000.00</b>	<b>29,112,000.00</b>	<b>36.39</b>	<b>50,888,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,000,000.00</b>	<b>29,112,000.00</b>	<b>36.39</b>	<b>50,888,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	80,000,000.00	29,112,000.00	36.39	50,888,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,354,939,700.00</b>	<b>1,242,820,034.25</b>	<b>91.73</b>	<b>112,119,665.75</b>
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,272,939,700.00</b>	<b>1,211,708,034.25</b>	<b>95.19</b>	<b>61,231,665.75</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,272,939,700.00	1,211,708,034.25	95.19	61,231,665.75
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>82,000,000.00</b>	<b>31,112,000.00</b>	<b>37.94</b>	<b>50,888,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	82,000,000.00	31,112,000.00	37.94	50,888,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>731,371.12</b>		<b>(731,371.12)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>4,746,665.22</b>		<b>(4,746,665.22)</b>

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>38,594,800.00</b>	<b>38,055,421.26</b>	<b>98.6</b>	<b>539,378.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>38,594,800.00</b>	<b>38,055,421.26</b>	<b>98.6</b>	<b>539,378.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,594,800.00</b>	<b>38,055,421.26</b>	<b>98.6</b>	<b>539,378.74</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,594,800.00</b>	<b>35,055,421.26</b>	<b>98.5</b>	<b>539,378.74</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,055,700.00	11,055,421.26	100.0	278.74
210302	Түлш, халаалт	24,039,100.00	24,000,000.00	99.8	39,100.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	0.00	0.0	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>3,000,000.00</b>	<b>100.0</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	100.0	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>38,594,800.00</b>	<b>38,055,421.26</b>	<b>98.6</b>	<b>539,378.74</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>38,594,800.00</b>	<b>38,055,421.26</b>	<b>98.6</b>	<b>539,378.74</b>
320001	Орон нутгийн төсвөөс	38,594,800.00	38,055,421.26	98.6	539,378.74

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 18,853.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

#### 3.1 Залруулсан алдаа

- Төсвийн жилд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг гаргаж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 заалтад заасан “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалтыг хэрэгжүүлээгүй, “нийцсэн болон зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байсныг аудитын явцад нөхөж бэлтгэсэн.
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор урьдчилан шилжүүлж, биетээр оршин байхгүй 2,312.0 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансанд бүртгэсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 заалт “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул урьдчилгаа дансанд бүртгэж, бараа материалын үлдэгдлээс хасч залруулсан.
- Бараа материалын дансанд бүртгэлтэй байсан хугацаа дууссан 10,628.7 мянган төгрөгийн эм тариаг акталж устгасныг тайлант үеийн эмийн зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй алдааг илрүүлж, аудитын явцад бараа материал акталсны зардалд бүртгэж залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,912.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 16,539.2 мянган төгрөгөөс 10,626.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.2 Албан шаардлага

- Улаан-Уул сумын эрүүл мэндийн төв нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй, дээд шатны төсөв захирагчаар батлуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 48 дугаар зүйлийн 48.2.1 "Худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах;" гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20,000.0 мянган төгрөгөөс 22,676.7 мянган төгрөгийн эм, 26,645.6 мянган төгрөгийн шатахуун, 6,644.5 мянган төгрөгийн хоол хүнсийг хэтрүүлэн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.” заалттай нийцэхгүй “нийцсэн

бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэнтэй холбоотой болон бусад шинээр гарсан дүрэм, журамтай нийцэхгүй болсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамтай нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөх.

#### **2. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар**

##### Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн Зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэсэн ганц шалгуураар 5,912.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

#### **3. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудал**

##### Илрүүлэлт:

2024 онд 1,310,858.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилснээс 17,944.5 мянган төгрөг хасагдсан нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх;”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын 3.1 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж...” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны цахим системийн дотоод хяналтыг сайжруулж, хасагдалтын хэмжээг өмнөх оноос бууруулах.

**4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Тус эрүүл мэндийн төв Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 30, зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 12 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.1.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:”, 6.4.”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**5. Ахмадын сангийн талаар**

**Илрүүлэлт:**

Улаан-Уул сумын эрүүл мэндийн төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1	-	1	-			1	-		
Жилийн эцэст шатахууны мөнгө шилжүүлж, биетээр байхгүй шатахууныг орлогод авсан	1	2,312.0			1	2,312.0	1	2,312.0		
Хугацаа дууссан 10,628.7 мянган төгрөгийн эм тариаг акталж устгасныг тайлант үеийн эмийн зардлаар бүртгэсэн	1	10,628.7			1	10,628.7	1	10,628.7		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>12,940.7</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>12,940.7</b>	<b>2</b>	<b>12,940.7</b>		

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй.	1	-					1	-
Бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо холбогдох шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаж үзээгүй, зөвхөн "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан гэж урамшуулсан байна.	1	5,912.3					1	5,912.3
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>5,912.3</b>					<b>2</b>	<b>5,912.3</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 30, зарлагын 1 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 12 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Шууд худалдан авалтын дүн нь засгийн газраас тогтоосон дээд хязгаараас давсан.	1	-					1	-
Тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд оруулж, батлуулаагүй	1	-					1	-
Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг цахим системд бүрэн, үнэ зөв оруулаагүйгээс нэхэмжилсэн санхүүжилтийг бүрэн авч чадаагүй.	1	-					1	-
Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж, батлуулаагүй байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>-</b>					<b>2</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

№ НН/А22Х069/

Мөрөн сум

ХВА-4025/065/НА-ЦА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор тогтоосон шууд худалдан авч болох барааны төсөвт өртгийн дээд хязгаараас 22,676,558 (хорин хоёр сая зургаан зуун далан зургаан мянга таван зуун тавин найм) төгрөгийн эм, 26,645,592 (хорин зургаан сая зургаан зуун дөчин таван мянга таван зуун ерэн хоёр) төгрөгийн шатахуун, 6,644,452 (зургаан сая зургаан зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун тавин хоёр) төгрөгийн хоол хүнс, нийт 55,966,602 (тавин таван сая есөн зуун жаран зургаан мянга зургаан зуун хоёр) төгрөгөөр хэтрүүлэн худалдаж авсан байна.

2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас tender.gov.mn-д худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулж, батлуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 44 дүгээр зүйлийн 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ." заалттай тус тус нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажиллах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дээд шатны төсвийн захирагчид цахимаар илгээж батлуулж байх, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор гаргаж, төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Нарангарвуу, нягтлан бодогч Б.Баярмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЕНОБААГАР

Г.ИЧИНХОРЛОО

87240-0514